

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ 10 ДУГААР САРЫН ТОВЧ ТАЙЛАН

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал тайлант хугацаанд 2 удаа хуралдаж, 8 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2019, 2020 оны төсвийн төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлийн үр дүн, түүнтэй холбогдох мэдээллийн ил тод байдал, иргэдийн оролцоо” сэдэвт хяналтын сонсголыг зохион байгуулж, оролцогч, ажиглагчдад мэдээлэл хийн, ороцогчид асуулт асууж, санал бодлоо илэрхийллээ. Орон нутгийн “Алтай” телевиз, “Алтайн мэдээ” сонин мэдээллийг иргэдэд хүргэлээ.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл хуралдаж, хууль сурталчилах ажилд 18 сум, 2 тосгоны төрийн болон иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудын албан хаагчдыг хамруулж, мэдээлэл сурталчилгааны ажил зохион байгуулахаар ажлын төлөвлөгөөг гарган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

НҮБ-ын ерөнхий Ассамблейн 76 дугаар хурлаар МУ-ын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-ийг эхлүүлсэнтэй холбогдуулан аймгийн Засаг дарга О. Амгаланбаатар 2030 он хүртэл аймагтаа “108 сая мод тарьж, ургуулах” аяныг эхлүүлж, аяны нээлтийг 10 дугаар сарын 5-ны өдөр Тайшир сумд зохион байгууллаа.

Хөдөө аж ахуйн болон хот суурин газрын өвөлжилтийн бэлтгэл, орон нутаг дахь коронавирусийн халдварын нөхцөл байдал, хадлан бэлтгэл, малын гоц халдварт өвчний голомт, отор нүүдлийн зохицуулалтын ажилтай газар дээр нь танилцаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхөөр Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яамны дэд сайд Г.Батсууриар ахлуулсан “Шуурхай бүлэг” 10 дугаар сарын 19-ний өдөр тус аймагт ажиллалаа. Сумдын 2021-2022 оны төв суурингийн өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 27 арга хэмжээний тодотгосон төлөвлөгөөг бүх сум, агентлагуудад хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажиллалаа. Төлөвлөгөөний биелэлт 71.1 хувьтай байна.

Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар, ХААИС-тай байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдөр "Говь-Алтай газар тариалан-2030" арга хэмжээг зохион байгууллаа. Уг арга хэмжээний үеэр "Газар тариалан жимс жимсгэнэ" хөтөлбөрт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж буй ХААИС-ийн эрдэмтэн докторууд аймгийн байгаль, цаг уурын онцлогт тохирсон газар тариалангийн үйлдвэрлэл, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр техник эдийн засгийн үндэслэлээ боловсруулж аймгийн удирдлагуудад гардуулан өгсөн ба Ерөнхийлөгчийн “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжиж аймгийн Засаг даргын санаачилсан “108 сая мод тарьж, ургуулах” аяны техник эдийн засгийн үндэслэлийг олон нийтэд таниулан сурталчиллаа.

Тус аймагт газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, хөдөө аж ахуйн салбарт орчин үеийн техник технологийн дэвшлийг нэвтрүүлэхэд мэргэжлийн чадварлаг

боловсон хүчин хамгийн чухал байгаа учир Хөдөө аж ахуйн их сургуульд хүсэлт тавьсны дагуу тус сургууль салбар сургуулиа албан ёсоор нээж, 11-р сарын 1-ний өдрөөс эхлэн хичээллэхээр бэлтгэл ажил хангагдаад байна.

Гамшгаас хамгаалах чиглэлээр: Аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А/464 дүгээр захирамжаар Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын хариу арга хэмжээний явцын үнэлгээг хийж, тайланг Улсын Онцгой комиссын нэгдсэн Шуурхай штабт цахим хаягаар хүргүүллээ.

Шадар сайдын 2021 оны 68 дугаар тушаалын дагуу аймгийн хэмжээнд зудын эрсдэлийн ерөнхий үнэлгээнд шаардлагатай мэдээллийг холбогдох мэргэжлийн байгууллагуудаас авч нэгтгэн сум бүрээр нарийвчлан гаргаж, дүнг улсын Онцгой комиссын даргын тушаалаар томилогдсон “Ажлын хэсэг”-ийн бүрэлдэхүүнд танилцууллаа.

Гамшгийн шуурхай удирдлагын газар, Баруун бүсийн төв Ховд аймгийн Онцгой байдлын газар, Ус цаг уур орчны шинжилгээний газраас ирүүлсэн цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээллийг аймгийн Онцгой комиссын гишүүд, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, малчид, иргэдэд нийт 2 удаа 12400 иргэнд “Багц мессеж”-ээр, байгууллагын цахим хуудас, аймгийн 8 фэйсбүүк хуудсаар байршуулж хүргэлээ.

Талант хугацаанд нийт 4 удаагийн гал түймрийн дуудлага хүлээн авч 1 дуудлагыг зөрчлийн мэдээгээр танилцуулж, 3 гал түймэр дээр гал унтраах тархалт хийн 65 литр шатахуун, 5.2 тонн гал унтраах бодис зарцуулж, 18 сая төгрөгийн эд хөрөнгийг авран хамгааллаа.

Коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах ажлын хүрээнд аймгийн Онцгой комиссын хуралдааныг тайлант хугацаанд 4 удаа хуралдуулж, үндсэн 15, нэмэлтээр 4, нийт 19 асуудал хэлэлцэж, 22 төрлийн шийдвэр, 1 удаагийн албан даалгавар, 6 удаагийн албан бичгийг байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Үйлчилгээний нэгдсэн төвийн талаар: Үйлчилгээний нэгдсэн төвд 7 байгууллагын 14 ажилтан 157 нэр төрлийн үйлчилгээг давхардсан тоогоор 1500 гаруй иргэнд нэг цэгээс түргэн шуурхай хүргэн ажиллалаа.

Өргөдөл гомдлын талаар: Тайлант хугацаанд нийт 14 өргөдөл бичгээр ирснээс 5 өргөдлийг шийдвэрлэж, 2 өргөдлийг Цагдаагийн газар болон Есөнбулаг сумын ЗДТГ-т албан бичгээр шилжүүлэн, 7 өргөдөл хяналтын хугацаандаа судлагдаж байна. Шийдвэрлэлт 35.71% байна.

“Иргэдээ сонсох нээлттэй утас 7048-1111” дугаарын утсанд 10 дугаар сарын байдлаар нийт 63 дуудлага хүлээн авснаас, хувийн мэдээллээ бүрэн өгсөн 49 гомдол, санал, хүсэлтийг E-office программд бүртгэн, холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн, шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна. Шийдвэрлэж хариу өгсөн 32, хугацаандаа судлагдаж байгаа 17, хугацаа хэтэрсэн 1 өргөдөл байна. Шийдвэрлэлт 65.3% байна.

Цахим үйлчилгээний талаар: E-Mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн цахим операторын системээр нийт 54 нэр төрлийн лавлагаа, мэдээллийг иргэдэд нэг шатлалаар олгож байна.

Тайлант хугацаанд операторын системээр иргэдэд олгох боломжтой 54 төрлийн төрийн цахим мэдээллийн үйлчилгээг 2 иргэнд төлбөртэй, 41 иргэнд төлбөргүй, нийт 43 лавлагаа мэдээлэл гаргаж үйлчиллээ.

WWW.OPERATOR.E-MONGOLIA.MN цахим мэдээллийн системээр үзүүлсэн лавлагаа, тодорхойлолтын үйлчилгээний хураамжийн 2500 төгрөгийг холбогдох дансанд төвлөрүүлээ.

Төрийн цахим үйлчилгээний E-mongolia сайтыг иргэдэд танилцуулах, шаардлагатай лавлагаа тодорхойлолтуудыг нэг шатлалаар богино хугацаанд авах, цахим порталын хэрэглээг нэмэгдүүлэх үүднээс үйлчилгээний нэгдсэн төвөөс иргэдэд мэдээ мэдээлэл, заавар зөвлөмжийг байнга өгч ажиллалаа. Иргэдийн хүсэлтээр хувийн мэдээллээр нь бүртгэл үүсгэж, хэрэгцээтэй лавлагаа тодорхойлолтуудыг 141 иргэнд үнэ төлбөргүй гарган үйлчиллээ.

Сумдын цахим мэдээлэл лавлагааны дүнг нэгтгэж, тайлан мэдээг Харилцаа холбооны зохицуулах хороонд сар бүрийн 05-ны дотор хүргүүлэн ажиллаж байна.

Үйлчлүүлэгчдийн хэвлэх, олшруулах үйлчилгээг 260 иргэнд үзүүллээ.

Аймгийн Засаг дарга, сумдын удирдлагуудтай цахим хурал хийж, малын гоц халдварт “Шүлхий” өвчин гарсантай холбогдуулан үүрэг чиглэл өглөө.

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 190 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд төрийн байгууллагууд 2021 онд хийсэн ажлаа иргэдэд сурталчилан таниулах, төрийн үйлчилгээг нэг дороос хүргэх, төрийн байгууллагын үйл ажиллагааны талаар иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авах, хэрэгжүүлэх зорилгоор “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээг 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдөр “Жанчив баатар”-ын талбайд зохион байгууллаа.

Тус арга хэмжээнд нийт 60 төрийн байгууллага оролцож, 2021 онд иргэдрүү чиглэн хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг танилцуулан санал, хүсэлтийг хүлээн авч, холбогдох мэдээлэл өгч, чиг үүргийн дагуу үйлчилгээ үзүүллээ.

Ерөнхий сайдын аймгийн Засаг даргатай байгуулсан батламж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3-р улирлын биелэлт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас 2021 оны 03 дугаар улирлын байдлаар гарсан аймгийн Засаг дарга болон Засаг даргын Тамгын газарт даалгасан заалт бүхий 51 тогтоолын хэрэгжилт, аймгийн Засаг даргын 03 дугаар улирлын байдлаар гарсан захирамж, албан даалгаврын хэрэгжилт, Монгол Улсын Шадар сайд, Хүнс, хөдөө аж ахуйн сайдын хамтарсан албан даалгаврын биелэлт, Засгийн газрын өргөтгөсөн хуралдаанаас аймаг, нийслэлийн Засаг дарга, ИТХ-н дарга нарт өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлтэд тус тус хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох зөвлөмжийг хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Засгийн газрын 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны 53 дугаар тэмдэглэлээр өгөгдсөн 2021 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжилт нь удаашралтай, гүйцэтгэл нь хангалтгүй үнэлэгдсэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн холбогдох заалтуудыг жагсаалтаар гаргаж, аймгийн ЗДТГ-ын даргын

2021 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 3/1003 дугаар албан бичгээр хэлтэс, агентлагийн дарга нарт хүргүүлээ.

Аймгийн Онцгой байдлын газар болон Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт 2021.10.12-ны өдрийн 10/1009, 10/1010 дугаар албан бичгээр зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг хангууллаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс 22-ны өдрүүдэд Байгаль, орчин аялал жуулчлалын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Эрүүл мэндийн газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Боловсролын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар, Орон нутгийн өмчийн газар, Соёлын хэлтэст зөвлөн тусалж, холбогдох албан тушаалтнуудад зөвлөмж, чиглэлийг өгч ажиллалаа.

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон сум, агентлагийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын талаар сургалт зохион байгуулж, 10 агентлагийн 97 албан хаагчийг хамруулан, чадавхжууллаа.

Статистикийн чиглэлээр: ҮСХ-нд дамжуулдаг графикт сар, улирлын мэдээг 10 сарын 4, 21-нд хугацаанд нь дамжуулсан ба аймгийн нийгэм эдийн засгийн гуравдугаар улирлын мэдээллийг гаргаж хэрэглэгчдэд хүргэлээ.

Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тооллогын хүрээг 18 авч, ҮСХ-д дамжууллаа.

ХОЁР. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ХЭГ/2394 албан бичгийн дагуу Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (шинэчилсэн найруулга)-тай бусад хууль тогтоомжийг нийцүүлэх, хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, нэр томъёог жигдлэх зорилгоор боловсруулсан Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон бусад хуульд, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй танилцан холбогдох газар, хэлтсүүдээс санал авах ажлыг зохион байгуулсан.

2021 онд шинээр батлагдсан, нэмэлт, өөрчлөлт орсон болон 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөгдөх хууль тогтоомжуудын эрх зүйн системчлэл, бүртгэлийн ажлыг хийлээ.

Авлигатай тэмцэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Архивын ерөнхий газраас тус тус зохион байгуулсан цахим уулзалт, сургалтад аймгийн удирдлагууд, агентлагийн дарга нар, эрх бүхий албан тушаалтнууд, сумдын нотариадын үүрэг гүйцэтгэгч, нийт 63 албан хаагч оролцож мэдлэг чадвараа дээшлүүлэн, мэдээлэл авлаа.

“Нотлох баримт гаргуулах тухай” 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн №102/ШЗ2021/12964 дугаар шүүгчийн захирамжийн дагуу “Ханлиг-Тайшир” ХХК-тай

холбогдох баримтыг нотлох баримтын шаардлага хангуулан Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд хүргүүлээ.

Авлигатай тэмцэх газраас аймгуудад цахимаар ажиллах удирдамжийн дагуу 9 төрлийн баримт материалыг файлаар хүргүүлээ.

Архивын тасаг: Архивын баримтаас иргэдийн хүсэлтийн дагуу 200 иргэнд мал тооллого, цалингийн лавлагаа болон тушаалын хуулбар нийт 630 хуудас баримт хувилж олшруулан, 1753.5 мянган төгрөгийг Төрийн сангийн дансанд төвлөрүүлж, иргэдэд үйлчилгээ үзүүлээ. Мөн сумдын Нийгмийн даатгалын байцаагч нараас ирсэн 50 хүний захиалгыг шүүж иргэдэд нь хүргэлээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын “Төрийн архивын үйл ажиллагаанд улсын үзлэг зохион байгуулах тухай ” 2021 оны А/173 дугаар тушаалын дагуу Архивын Ерөнхий газрын Мэдээлэлийн технологийн газрын дарга Х.Төмөрбаатараар ахлуулсан ажлын хэсэг 10 сарын 11-ний өдрөөс 14-ний өдрүүдэд ажиллалаа. Тус үзлэгийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсрууллаа.

Прокурорын газрын байнга хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл болон Баян-Уул сумын Засаг даргын 30 захирамжийг тус тус хяналаа.

Хууль, эрх зүйн хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу аймгийн Орон нутгийн өмчийн газар, Татварын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Боловсролын газрын Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд тс тус тус хяналт шалгалт хийж, зөвлөн тусалж ажиллаа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар: 2021 оны 10 дугаар сард өмнөх оны үлдэгдэл 272 гүйцэтгэх баримт бичгийн 2116699.2 мянган төгрөгийн, шүүхээс шинээр 308 гүйцэтгэх баримт бичгийн 1632449,0 мянган төгрөг, 1 гүйцэтгэх баримт бичгийн 28365,0 мянган төгрөгийн төдбөрийг шүүгчийн захирамжийн дагуу сэргээж 6 гүйцэтгэх баримт бичгийн 190235,8 мянган төгрөгийг төлбөр авагчийн хүсэлтээр буцааж, 7 гүйцэтгэх баримт бичгийн 87065,1 мянган төгрөгийг газар хооронд харьяаллын дагуу шилжүүлж, 23 гүйцэтгэх баримт бичгийн 114809,1 мянган төгрөгийг түдгэлзүүлэх ажиллагаа явуусан бөгөөд бодит биелэлт 52,9 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3 хувиар, улсын дундажаас 8,4 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Шүүхийн шинжилгээний алба:Тайлант хугацаанд эрүүгийн хэрэгт мөрдөгч, прокурорын тогтоолыг үндэслэн 2 криминалистикийн шинжилгээ хийж, хэргийн газрын үзлэгт 29 удаа оролцсоноос хүний амь нас хохирсон 7, хулгайлах 9, зам тээврийн ослын 7, бусад 6 хэрэгт тус тус үзлэг шинжилгээ хийлээ. Мөн шинжилгээний 14, хэргийн газрын үзлэгийн 1082, цогцосны үзлэг, задлан шинжилгээний 210, нийт 1516 гэрэл зураг авсан.

Гарын хээний дардас 98, гарын мөр 13 ширхэгийг хийж гарын мөрний санг баяжуулсан.

Химийн шинжилгээ 10, биологийн шинжилгээ 6, нийт 16 тусгай шинжилгээ хийсэн.

Улсын бүртгэлийн хэлтэс:Иргэний бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд шуурхай чирэгдэлгүй, чанартай хийж цахим

мэдээллийн сангийн баяжилтыг тухай бүр хийж ажиллалаа. Тайлант хугацаанд 293 лавлагаа олгож, 18 гадаад паспортын захиалга хийж, 10 хуулийн этгээдийг бүртгэн гэрчилгээ олголоо.

Иргэд хуулийн этгээдийн эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой бусад эрхийн 382 мэдүүлэг хүлээн авч шийдвэрлэн, бүртгэлийн үйлчилгээний хураамж 3590.5 мянган төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 593.0 мянган төгрөг, татварын орлого 18158.0 мянган төгрөгийг тус тус улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүллээ.

Улсын бүртгэлд тогтоосон хугацаанд бүртгүүлээгүй журам зөрчсөн үйлдэлд хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж 20 иргэнд 400.0 мянган төгрөгийн торгууль ногдуулсан. Мөн иргэний бүртгэлийн чиглэлээр 2, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл 3, нийт 5-н дүгнэлтээр зөрчлийг арилгаж шийдвэрлэлээ.

Цагдаагийн газар: 2021 оны эхний 10 дугаар сард гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 1545 гомдол, өргөдөл мэдээлэл хүлээн авч шалгаснаас гэмт хэргийн шинжтэй 401, зөрчлийн шинжтэй 1144 гомдол, мэдээлэл байна. Гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 1545 гомдол, өргөдөл, мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 388 нэгжээр буюу 33.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн болон зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 935 буюу 62,2 хувийг хуулийн анхны хугацаанд шийдвэрлэж, нийт хүлээн авсан гомдол, мэдээллийн 98.2 хувийг шийдвэрлээд байна.

2021 оны эхний 10 сард аймгийн хэмжээнд төрийн болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өмч хөрөнгөд 586.1 сая төгрөгийн хохирол учирсан 189 гэмт хэрэг үйлдэгдсэнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 45 хэргээр буюу 31,3%-иар өсч, учирсан хохирол 66,5 сая төгрөгөөр буюу 10%-иар буурсан үзүүлэлттэй байна.

189 гэмт хэрэгт нийт 149 хүн холбогдож, гэмт хэргийн улмаас 7 хүн нас барж, 76 хүн гэмтсэн байна.


Хөнгөн гэмт хэрэг 149 бүртгэгдсэн нь 44 нэгжээр буюу 42.0 хувиар, хэрэг бүртгэлтийн хэрэг 114 бүртгэгдэж 19 нэгжээр буюу 20 хувиар, мөрдөн байцаалтын хэрэг 75 бүртгэгдэж 26 нэгжээр буюу 53,1 хувиар, хүнд гэмт хэрэг 40 бүртгэгдсэн нь 1 хэргээр буюу 2,6 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн бүлэглэлээр нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулан үзвэл:

	2020 оны эхний 10 сар	2021 оны эхний 10 сар	Гэмт хэргийн өсөлт, бууралт	
			тоо	хувь
 Хүний амьд явах эрхийн эсрэг	3	4	1	33,3%
 Хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг	38	62	24	63.2%

	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	5	6	1	20%
	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг	-	-	-	-
	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг	-	-	-	-
	Эрүүл мэндийн эсрэг	-	-	-	-
	Хүүхдийн эсрэг	-	-	-	-
	Өмчлөх эрхийн эсрэг	80	82	2	2.5%
	Үүнээс: Хулгайлах	45	33	-12	-27%
	Үүнээс: Хувийн өмчийг хулгайлах	44	27	-17	-39%
	Үүнээс: Автотээврийн хэрэгсэл хулгайлах	1	5	4	5 дахин өссөн
	Үүнээс: Халаасны хулгай	-	-	-	-
	Үүнээс: Галт зэвсэг хулгайлах	-	-	-	-
	Дээрэмдэх	-	-	-	-
	Залилах	17	37	20	2,2 дахин
	Хөрөнгө завших	6	4	-2	-33,3%
	Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших	2	3	1	50%
	Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх	-	-	-	-
	Автотээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүй авч явах	-	-	-	-
	Эд хөрөнгийг устгаж гэмтээх	-	-	-	-
	Бусдын эд хөрөнгийг устгах, гэмтээх, үрэгдүүлэх	-	1	1	-
	Мал хулгайлах	10	4	-6	-60%

	Эдийн засгийн	-	-	-	-
	Үндэсний аюулгүй байдлын эсрэг	-	-	-	-
	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	-	9	9	-
	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг	-	-	-	-
	Авлигын	2	-	-2	-
	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг	-	-	-	-
	Хүрээлэн байгаа орчны эсрэг	8	12	4	50%
	Соёлын өвийн эсрэг	-	-	-	-
	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг	-	-	-	-
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг	7	13	6	86%
	Цэргийн албаны эсрэг	-	1	1	-
	Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайны эсрэг	-	-	-	-



Тус аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 42,1 хувь байгаа нь улсын дунджаас 6,3 нэгжээр доогуур байна.

Зөрчил: Нийгмийн хэв журам зөрчсөн 11839 зөрчил илрүүлэн 11779 зөрчлийг шийдвэрлэлээ.

Зөрчил гаргасан 11283 иргэн, 10 хуулийн этгээдийг 458011.5 мян төгрөгөөр торгох, 183 иргэнийг баривчлах, 303 иргэнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус тус ногдуулсан байна.

Нийт зөрчлийн 635 буюу 65 хувь нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ зөрчил үйлдсэн байна.

ГУРАВ. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮ, ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Аймгийн төсөв санхүүгийн чиглэлээр: Эхний 10 сарын гүйцэтгэлээр орон нутгийн төсөвт 5362.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 6887.9 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 128.4 хувиар, улсын төвлөрсөн төсөвт 1315.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 1561.5 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 103.2 хувиар тус тус биелүүлсэн бөгөөд урьд оны 1304.0 сая төгрөгийн өрийг барагдууллаа.

Төсвийн зарлага 57027.5 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 54915.0 сая төгрөгийн буюу 96.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тусгай зориулалтын шилжүүлгээр 31598.2 сая төгрөг, улсын төсвийн санхүүгийн дэмжлэгээр 10528.7 сая төгрөгийг тус тус хуваарийн дагуу бүрэн авч сум, байгууллагуудын дэмжлэгийг бүрэн олголоо.

Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгээр 7402.7 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 6527.6 сая төгрөгийн санхүүжилт авч 88.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Худалдан авах ажиллагаа: Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2021 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөө, түүнд хийсэн тодотголын дүнгээр 12.0 тэрбум төгрөгийн 97 төсөл арга хэмжээг төлөвлөж, 91 арга хэмжээг хялбаршуулсан буюу цахим хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд бараа 30, ажил 27, зөвлөх үйлчилгээ 13, зөвлөхөөс бусад үйлчилгээ 1 байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулинд өөрчлөлт оруулах талаарх 3 удаагийн хэлэлцүүлэгт ОНӨГ-ын албан хаагчид хамрагдаж, санал хүсэлтийг хүргүүллээ.

Өмчийн асуудлаар: Авилгатай тэмцэх газраас зохион байгуулсан цахим сургалтад бүх албан хаагчдыг хамрууллаа.

Тайлант хугацаанд 4 ажлыг ашиглалтад хүлээн авах улсын комисст ажиллан өмчид бүртгүүлэх ажлыг зохион байгууллаа.

Орон нутгийн өмчит 6 байгууллагын өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж өмч эзэмшлийн гэрээ байгуулж, гэрээг дүгнэх чиглэлээр, 4 сумд “Газар тариалан жимс жимсгэнэ” төсөл арга хэмжээний хөрөнгө оруулалтын

үр дүнд бий болсон хөрөнгийг орон нутгийн өмчид хүлээн авах, бүртгүүлэх чиглэлээр, “Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар” УТҮГ-ын үйл ажиллагаатай танилцаж, тус үйлдвэрийн газрын өмч хөрөнгийг нь тухайн байгууллагад шилжүүлэх, орон тоо бүтэц, үйл ажиллагаанаас орсон орлогын төлөвлөлт, зарцуулалтад хяналт тавих чиглэлээр тус тус ажиллаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын мэдэлд шилжсэн “АНДУУД” хүүхдийн зуслангийн өмч хөрөнгийн тооллого хийж, одоогийн байгаа байдалд үнэлэлт дүгнэлт өгч, барилгуудын засварын зураг төслийг боловсруулан цаашид хэрхэн үр дүнтэй ажиллуулах талаарх саналыг холбогдох дээд байгууллагад уламжлахаар шийдвэрлэлээ.

Орон нутгийн төсөвт хөрөнгө худалдан борлуулсны орлого 900.0 мянган төгрөг, акталж үнэ тогтоон худалдан борлуулсны орлого 186.0 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлээд байна.

ДӨРӨВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

Аймгийн хэмжээнд 88 багийн 7915 малчин өрхөд нийт 3196.1 мянган толгой буюу хонин толгойд шилжүүлснээр 4281.1 мянган толгой мал өвөлжиж, хаваржихаар байгаа бөгөөд дотоодын хэрэгцээнд 313.8 мянган толгой мал, зах зээлд 525.9 мянган толгой мал, нийт 839.7 мянган толгой малыг борлуулах тооцоо судалгаа гарсан.

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс 2021-2022 оны өвөл, хаврын бэлчээрийн даацыг (баг бүрийн бэлчээрийн ургац, малын тоо, бэлчээрийн талбайн хэмжээ, бэлчээр ашиглах хугацаа зэрэг мэдээлэл дээр үндэслэн багийн нутгаар тооцоолж) гаргасан. Аймгийн бэлчээрийн ургамлын ургалтын байдал 2021 оны 9 дүгээр сарын 11-ний байдлаар нийт нутгийн 79,0 хувьд хэвийн буюу сайн, 21,0 хувьд дунд (удаашралтай) гэсэн үнэлгээ гарсан.

Бэлчээрийн даац: Нийт нутгаар тооцоолж гаргасан дүнгээс үзвэл 17.1 % нь 50 хүртэлх хувь (бэлчээрийн нөөцтэй), 27.6 % нь 51-100 хувь (бэлчээр хүрэлцээтэй), 40.8 % нь 101-300 хувь (даац 1-3 дахин хэтэрсэн), 9.2 % нь 301-500 хувь (даац 3-5 дахин хэтэрсэн), 5.3 % нь 500 хувиас их (даац олон дахин хэтэрсэн) байгаа ба аймгийн нийт нутгийн 44.7 хувь нь хэвийн, 55.3 хувь нь бэлчээрийн хүрэлцээ муу гэсэн үзүүлэлттэй байна.

Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл хангуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын 2021 оны А/379 дүгээр захирамжаар томилон, ажлын төлөвлөгөө батлан хэрэгжилтийг ханган ажиллалаа. Тухайлбал: аймгийн аюулгүйн нөөцөд 150 тн өвс, 100 тн тэжээл, сум бүр аюулгүйн нөөцдөө 100 тн өвс, 30 тн тэжээл бэлтгэхийн зэрэгцээ малчдаар өвс тэжээл бэлтгүүлэх, бэлчээрийн даац хэтэрсэн сумдын малын тоог бууруулах, зах зээлийн эргэлтэд оруулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллаж байна. Аймгийн аюулгүйн нөөцөд 154 тн өвс, сумууд аюулгүйн нөөцдөө 525.3 тн өвс, 212.7 тн тэжээл, малчид 4569.6 тн өвс, 665.5 тн үйлдвэрийн тэжээл, 133.5 тн гар тэжээл, 4683.5 тн хужир шүү бэлтгээд байна. Төлөвлөгөөний биелэлт өвс 64.6 хувь, тэжээл 19.7 хувь, дундаж 42.1 хувьтай байна.

Отор нүүдэл: Аймаг дундын Бор аргалантын отрын бүс нутагт Дэлгэр болон Бууцагаан сумаас нийт 62 өрхийн 42.0 мянган толгой малыг өвөлжүүлэхээр шийдвэрлэсэн. Улсын тусгай хамгаалалттай бүс нутагт 4 сумын 277 малчин өрхийн 156.3 мянган толгой мал, Хилийн зурваст 1 сумын 52 өрхийн 22.0 мянган толгой мал, Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бүс нутагт 1 сумын 42 өрхийн 21.4 мянган толгой мал өвөлжиж, хаваржих урьдчилсан судалгаа гарсан. Мөн өөр аймгийн нутагт 1 сумын 5 өрхийн 2.0 мянган толгой мал, өөрийн аймгийн бусад сумын нутагт 3 сумын 14 өрхийн 4.7 мянган толгой мал өвөлжиж, хаваржихаар байна.

Мал сүргийн эрсдэлийг бууруулах зорилгоор малын индексжүүлсэн даатгалд 18 сумын 2937 малчин өрх 726.5 мянган толгой малаа даатгуулаад байна.

Аймгийн хэмжээнд нийт 1949 худаг байгаагаас инженерийн хийцтэй 515 худаг, энгийн уурхайн 1434 худаг ашиглагдаж байна.

Тайланд хугацаанд улсын төсвийн хөрөнгөөр 4 сумд 6, төсөл хөтөлбөрөөр 2 сумд 2, нийт 8 инженерийн хийцтэй худаг, малчид өөрсдийн хөрөнгөөр 12 энгийн уурхайн худгийг тус тус шинээр гарган, ашиглаж байна.

Ургац хураалт: Үр тариа 304.7 га, ногоон тэжээл 805.3 га, хүнсний ногоо 69.4 га, төмс 62.1 га, жимс, жимсгэнэ 141 га, хүлэмжийн аж ахуй 16641 м.кв талбайд нийт 1396 га талбайд тариалалт хийгдэж өмнөх оны мөн үеэс 152 га-гаар нэмэгдүүлсэн ба үр тариа 300 га-аас 443 тн, төмс 58 га-аас 449 тн, хүнсний ногоо 72 га-аас 438 тн, ногоон тэжээл 826 га-аас 2361 тн, жимс жимсгэнэ 141 га-аас 77 тн, нийт 1396 га талбайгаас 3767.9 тн ургац хураан авсан

Мал эмнэлгийн чиглэлээр: Мал эмнэлгийн цахим гэрчилгээг 23.2 тонн мах, 159 малд олголоо.

Аймгийн зарим сумдад малын гоц халдварт “Шүлхий” өвчин гарсантай холбоотой А/479 дугаар захирамжаар 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд хорио цээр тогтоон гадны аймаг, сум болон өөрийн аймгийн бусад сумдын нутаг дэвсгэрээс мал, амьтан нэвтрүүлэх, худалдах, отор нүүдэл, шилжилт хөдөлгөөн, уралдаан зохион байгуулах болон бусад чиглэлийн үйл ажиллагааг бүрэн хориглон, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Тус өвчний тархалтыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах зорилгоор Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын А/253 тушаалаар томилогдсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн голомтод бүсүүдэд ажиллан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.

Аймгийн хэмжээнд “Шүлхий” өвчний тархалтын голомт шинээр нэмэгдээгүй, 7 сумын 7 голомтын 109 өрхийн үхэр 875, хонь 1985, ямаа 3232, нийт 6092 мал өвчилсөн ба дархлаажуулалтад 10 тэмээ, 2589 үхэр, 36287 хонь, 67169 ямаа, нийт 119107 мал хамрагдаж гүйцэтгэл 90.65 хувьтай байна.

Халиун, Хөхморьт, Цогт, Баян-Уул, Тайшир сумдын сэжигтэй бүсийн 33 малчин өрхийн 20480 м² талбай бүхий малын хашаа хороо, 2540 м² талбай бүхий 46 худаг уст цэг, 4000 м² бэлчээрийн талбай, нийт 27020 м² талбайд халдваргүйтгэл хийлээ. Мөн 169940 м² талбайд, 158 ширхэг тээврийн хэрэгсэлд халдваргүйтгэл хийлээ.

Шарга, Тайшир, Есөнбулаг, Цогт, Халиун, Хөхморьт сумдын 95 малчин өрхийн 401 үхэр, 691 хонь, 1054 ямаа, нийт 2146 малд тэмдгийн эмчилгээ хийснээр шүлхий өвчний шинж тэмдэг арилсан.

Жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр: “Электрон-Алтай” ХХК чипсэн ааруул, бүх төрлийн идээний ааруул, “Баян-Алтай” ХХК цульхартай цайг үйлдвэрлэхэд зориулан ЖДҮХС-аас тус тус зээл олгон үйл ажиллагааг нь дэмжлээ. “Оюухулан” ХХК нь сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийн хөргөлтийн агуулахыг барьж ашиглалтад оруулсан бөгөөд 4 дүгээр улиралд багтаан тоног төхөөрөмжийг угсарч үйлдвэрийн үйл ажиллагааг эхлүүлэхээр ажиллаж байна. Сүү, цагаан идээ үйлдвэрлэх чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх 3 иргэнд 17.0 сая төгрөгийн зээлийг Сум хөгжүүлэх сангаас олгон, үйл ажиллагааг дэмжлээ.

Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, зээлийн эргэн төлөлтийг сайжруулах зорилгоор зээлийн мэдээллийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон Монголбанкны зээлийн мэдээллийн санд 18 сумын зээлдэгчдийн мэдээллийг нэгтгэн, сумуудтай тулгалт хийснээр 10 дугаар сарын байдлаар нийт 160 зээлдэгчийн 600.8 сая төгрөгийн зээлийг төлүүлсэн байна.

Стандарт хэмжил зүйн чиглэлээр: Шинэчлэн батлагдсан баримт бичгийн /MNS:5140-1,2,3-2021/ стандартын цахим сургалтыг 10 дугаар сарын 11 -ний өдөр зорион байгуулж, 18 сум, 2 тосгоны, 36 төрийн байгууллагын, 56 албан хаагч хамрагдаж, мэдлэг, чадвараа дээшлүүллээ.

ТАВ. ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Есөнбулаг сумын 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тодотголд тусгагдсан 5 нэгж талбар газарт газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг www.egazar.gov.mn цахим системээр зохион байгуулж байна.

Газрын харилцаа-Цахим шилжилт аяны төлөвлөгөөг гаргаж, www.egazar.gov.mn сайтыг хэрэглээнд нэвтрүүлэх сарын аяныг зарлан, иргэдэд газар өмчлөх, эзэмших, дуудлага худалдаа төсөл сонгон шалгаруулалт болон газар олголттой холбоотой асуудлаар иргэдэд мэдээлэл олгох нөхцөл, орчныг сайжруулан/тусгай өрөө гарган/, 70480330 дугаар суурин утсаар болон www.egazar.gov.mn сайтаар иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч, шийдвэрлэж байна. Мэдээллийг бүх сум, байгууллагуудад хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Аяны хүрээнд www.egazar.gov.mn цахим системд бүртгүүлэх шаардлагатай 35 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын өргөдлийг цахим болгох, 5 иргэн, 1 аж ахуйн нэгж байгууллагын мэдээллийг www.egazar.gov.mn цахим системд бүртгэн газар эзэмших эрхийн гэрчилгээ, гэрээ олгох, цахим ситемийг ашиглах тухай сумдын газрын даамлуудын сургалт зохион байгуулах, цахим систем дээр ажиллах гарын авлага боловсруулах, “Алтайн мэдээ агентлаг”-тай хамтран ажиллах гэрээ байгуулан өдөр тутмын мэдээллийг иргэдэд хүргэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Газрын төлбөр, татвар үнэлгээний системд 12 сумын төлбөрийн тулгалтыг хийж, 1184 нэгж талбарын засварыг газрын кадастрын мэдээллийн санд газрын төлбөрийн ногдуулалтыг хийлээ.

Барилга, хот байгуулалтын чиглэлээр: Орон нутаг хэрэгжиж буй төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн мэдээг Боловсрол шинжлэх ухааны яаманд bilgee073007@gmail.com, Барилга, хот байгуулалтын яаманд oyunjargal@mcud.gov.mn цахим хаягаар тус тус хүргүүлээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Баруун бүсийн уламжлалт анагаах ухааны эмнэлгийн засвар, Эрдэнэ, Дэлгэр сумдын Соёлын төвийн барилгын засвар, 8 дугаар цэцэрлэгийн барилгын их засварын ажил дуусч, улсын комиссын дүгнэлтээр байнгын ашиглалтад орууллаа.

Нэгдсэн эмнэлгийн “Б” блокны их засварын ажил, 5 дугаар сургуулийн дөрвөн замын уулзвараас Есөнбулаг ЗДТГ, Алтай Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн байр хүртэлх гудамжны тохижилт, ногоон байгууламжийн ажил, Тонхил сумын 320 хүүхдийн цэцэрлэгийн шинэ барилга, 3 дугаар сургуулийн спорт заалны барилга, 1 дүгээр сургуулийн спорт заалны барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн хугацааг тус тус сунгаж, Цогт сумын 500 хүний суудалтай спорт заалны барилга, Тонхил сумын 320 хүүхдийн сургуулийн барилга, НҮБ-ын Хүүхдийн сангийн хөрөнгөөр хэрэгжих Эрдэнэ сумын сургуулийн дотуур байрны ариун цэврийн барилгын өргөтгөлийн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжүүлэх зөвшөөрөл олголоо.

Барилгын материал үйлдвэрлэл, лабораторийн чиглэлээр: Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Ахмадын сувилал”-ын барилгын бетоны маркыг үл эвдэх аргаар, 2 дугаар сургуулийн спорт заалны барилгад хэрэглэж буй автоклавын хийт бетон гулдмайд, Эзвийн голын 65м/у төмөр бетон гүүрийн ажлын бетоны сорьцид, хувийн хөрөнгөөр хийгдэж буй “Аксу Алтай” ХХК-ийн бетон сорьц, полисторл хавтанг шинжилгээнд хамруулж үр дүнг холбогдох ААН-дэд хүргүүлээ.

Нийтийн аж ахуйн талаар: Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хооронд байгуулсан санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд Австри улсын 14.0 сая еврогийн хөрөнгөөр тус аймагт 2019 оноос эхлэн хэрэгжих буй “Тайшир-Алтайн усан хангамжийн төсөл”-ийн ажил дуусч 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Барилга хот байгуулалтын яамны 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн А/123 дугаар тушаалаар томилогдсон техникийн комиссын бүрэлдэхүүн ажиллаж, 2021 оны 10 дугаар сарын 30-нд “Тайшир-Алтай ус хангамж” төслийг хүлээлгэн өгөх арга хэмжээг зохион байгуулж, УИХ дарга Г.Занданшатар, УИХ гишүүн Ш.Раднаасэд, УИХ гишүүн бөгөөд БХБ-ын сайд Д.Мөнхбаатар, ЭМ-ийн сайд Б.Энхболд, ЭХ-ний сайд Э.Тавинбэх, БНАУ-ын Ти Ар Эм ХХК болон холбогдох албан тушаалтанууд оролцлоо.

“Ундарга-Алтай” ААТҮГ нь 4 гүний худаг, 1 нөөцийн худагтайгаар үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тайлант хугацаанд Алтай хотын ард иргэдэд 165006м3 ус олборлон түгээсэн байна.

Дэд бүтцийн салбарт: Гуулин УЦС-ын хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг хийж эхэлсэн. Эрдэнэт үйлдвэрээс шилжүүлж өгсөн тоног төхөөрөмжийг Гуулин УЦС-д

суурилуулснаар үйлдвэрлэл 1,5мв-ын хүчин чадалтай бөгөөд станцын хүчин чадлыг 3-4 дахин нэмэгдүүлэхээр тооцоологдсон. “Алтай-Улиастайн ЭХС” ТӨХК-ийн өвөлжилтийн бэлтгэл ажил 90 хувийн хангалттай, шаардлагатай тоног төхөөрөмжөө шинэчлэх засварлах ажлууд төлөвлөгөөний дагуу хийгдэж байна.

Зам тээврийн чиглэлээр: Тайлант хугацаанд Аэромонголиа ХХК-ийн 5, Mongolian airways ХХК-ийн 3, нийт 8 удаагийн нислэгийн аюулгүй байдлыг ханган ажилласан ба Улаанбаатар –Алтайн чиглэлд 190 зорчигч зорчин, рейсийн болон захиалгат, дамжин нислэгийн аюулгүй ажиллагааг хангалаа.

Тайлант хугацаанд техникийн хяналтын үзлэг хийж, нийт 520 тээврийн хэрэгсэл техникийн үзлэгт хамрагдлаа. Хот хоорондын зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээнд 54 тээврийн хэрэгслээр 1738 зорчигч хамрагдсан байна.

Мэдээлэл харилцаа холбооны чиглэлээр: Аймгийн төв болон Баянтоорой тосгон, Бугат, Бигэр, Цогт сумдад ажиллаж, Юнителийн захиалгат ажлыг хийж гүйцэтгэсэн ба сүлжээ шинээр орууллаа. Төгрөг, Бугат сумдад үндсэн сүлжээний сайжруулалт, Бугат сумд Мобикомын WOS-2942, WOS-2931-н дагуу ашиглалтын менежер ажилласан. Алтай сумын Бургастай боомтод 0.6D антенна релей пол бургастай боомт гаалийн дээвэр дээр хийж, релей антенныг сайт болон гааль талд суурилуулах, мини UPS, IDU гаалийн серверийн өрөөнд суурилуулж шугам холболт өгөгдлийн сүлжээний SW холболт хийн холбогдох тоног төхөөрөмж холбоон дээр хүлээн авлаа.

Авто зам засвар арчлалт: 8м хүртэлх өргөнтэй хайрган замыг хэв дүрс гарган засаж тэгшлэх, замын зорчих хэсэг ба хөвөөний суларсан чулууг түүж зайлуулах, 1м3 өргөнтэй буталсан чулуун ба хайрган хучлаганд шинэ материал нэмж засвар хийх, замын тэмдэг ба километрийн тэмдэг суурилуулах, хайс дугуй цохигч, дохионы шон будах, төмөрбетон хоолой барих, Алтай-Баянхонгор чиглэлийн хөвөөний угаагдсан буюу суулт үүссэн хэсэгт механизмаар шороо нэмж засах, ус зайлуулах шуудууны хэв дүрсийг автогрейдэрээр хэсэгчлэн сэргээх, асфальтобетон хучлагын 3 м2 хүртэлх талбайтай нүхийг халуун асфальто бетоноор засварлах, асфальтобетон хучлагын ан цав, хагарлыг гар заадас цутгах төхөөрөмжөөр гагнах, мэдээллийн самбарын бичлэгийг засаж сэргээх, хайс дугуй цохигч будах төмөрбетон гүүрийн унасан парпет засварлах, овооны хог цэвэрлэх, замын тэмдэг ба километрийн тэмдэг суурилуулах, дохионы шон будах, суулгах, замын тэмдэглэгээг зориулалтын машинаар хийх, хоолойн амсар цэвэрлэх, Алтай-Улиастай чиглэлийн 8м хүртэлх өргөнтэй хайрган замыг хэв дүрс гарган засаж тэгшлэх, хучлаганд шинэ материал нэмж засвар хийх, замын тэмдэг ба километрийн тэмдэг суурилуулах, хайс дугуй цохигч будах, дохионы төмөр бетон шон будах зэрэг ажлыг хийж гүйцэтгэлээ.

Сургалт: “Газар тариалан жимс жимсгэнэ” төсөл арга хэмжээний хүрээнд жимс, жимсгэний модны намрын тариалалтыг хэрхэн хийх, өвөлжилтөд бэлтгэх талаар танхимын болон талбайн сургалтыг аймгийн Хөдөө аж ахуйн их сургууль, Дарханы “Ургамал Газар Тариалангийн Хүрээлэн, “Агро-Альфа” ХХК-тай хамтран 2021 оны 10 сарын 05-ны өдөр зохион байгуулж, чадавхжууллаа.

ЗУРГАА. НИЙГМИЙН САЛБАР:

Боловсролын чиглэлээр: БМДИ-ээс “Зөвлөх багш” зэргийн материалд дүгнэлт гаргаж ирүүлэх тухай, БШУЯ, БҮТ-өөс зохион байгуулсан “Сургуульд суурилсан үнэлгээг зохион байгуулах тухай, БШУЯ-аас зохион байгуулсан “Танхимын ба цахимын хосолсон сургалт явуулах тухай”, “Боловсролын үр дүнгийн үзүүлэлт дээр өгөгдлийн шинжилгээ хийх нь”, Ерөнхий боловсролын сургуулийн хөгжмийн багш нарт “Хөгжим, урлагийн боловсролын орчин үеийн чиг хандлага, арга зүйн онцлог, техник, өв уламжлалын талаарх шинэлэг, инновацилаг мэдлэг чадвар эзэмшүүлэн мэргэжлийн хөгжилд дэмжлэг үзүүлэх” тухай, “Цэцэрлэгийн дотор орчны агаарын бохирдолт үнэлгээ хийх, авах арга хэмжээ”, нийт 6 удаагийн сургалтад холбогдох албан хаагчид хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүллээ.

2021 оны 10 сарын 13-ны өдрөөс 27-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Сургуульд суурилсан үнэлгээ”-г хийж дүнг нэгтгэж байна.

Багш бүрийн үнэлгээний явц, тэмдэглэлтэй танилцан, тухайн багшийн үнэлгээний ололттой болон анхаарах асуудлын талаар зөвлөгөө өглөө. Тухайлбал:

Үнэлгээнд хамрагдсан сурагч бүрийн хариултыг тэмдэглэн, судалгааны сан бүрдүүлсэн, сурагч бүрийн гүйцэтгэлээр даалгаврын сангийн хавтас үүсгэсэн, биеийн тамирын багш нар үнэлгээнд хамрагдах сурагчдад зориулан дасгал, хөдөлгөөнийг хэрхэн гүйцэтгэх дараалал, алхмыг харуулсан зурагт үзүүлэнгүүд хийсэн нь ололттой үзүүлэлт байна.



Бага насны хүүхдийн стратеги төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнгийн талаар хэлэлцэж, цаашид хийх ажлын талаар хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Төрийн байгууллагуудын” Нээлттэй хаалганы өдөр” зохион байгуулах Засгийн газрын 2007 оны 190 дүгээр тогтоолын дагуу Боловсролын чиглэлээр хэрэгжүүлж байгаа бодлогын хэрэгжилтийн танилцуулгыг зурагт самбар гарган сурталчилж гадаад улсад тэтгэлэгтэй суралцах арга зам, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх видео зөвлөмжийг видео хэлбэрээр цацаж үнэлгээний шинэчлэл, цахим сурах бичиг ашиглах, боловсролын салбарын мэдээллийн системийн шинэчлэлийн талаар мэдээлэл хийж 500 ш хэвлэмэл материал тарааж иргэдийн ухаалаг утсанд application суулгаж үйлчилгээ үзүүллээ.

Мөн Боловсролын үйлчилгээний талаар иргэдээс цахим санал асуулга авч нэгтгэн дүгнэж, цаашид хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгах, шийдвэр гаргах түвшинд иргэдийн саналын дүнг харгалзахаар боллоо.

“Em Oyu ih” сургуулийн америк багш нартай хамтран Есөнбулаг сумын 5 сургуулийн 7-9 дүгээр ангийн сурагчдад англи хэлний ярианы клуб, 10-11 дүгээр ангийн сурагчдад англи хэлний ЭЕШ-д бэлтгэх сургалтыг 7 хоног бүр хуваарийн дагуу тус тус зохион байгуулж, сургалтад 1080 сурагч хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүлж байна. Мөн гадаад хэлний багш нарын ярианы клубыг зохион байгуулж, 19 багш хамрагдаж байна.

Төгсөх ангийн сурагчдад “Мэргэжил сонголт” -ын чиглэлээр уулзалт зохион байгуулж, 340 сурагч хамрагдан, мэдээлэл авлаа.

Соёлын чиглэлээр: “Үндэсний бичиг, өв соёл-Алтайн бахархал” уралдаанд сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулж, 54 албан хаагч хамрагдаж, 3.0 сая төгрөг зарцууллаа. Соёлын өвийг хамгаалах, уламжлагчдын мэдээллийг бүргэлжүүлэх ажлын хүрээнд “Их өвийн эрэлд” экспедицтэй хамтран контент болон, ном гаргах ажлыг хийж байгаа ба 8 сум 100 гаруй иргэнээс яриа авч,33 өвлөн уламжлагчаас аман хууч яриаг дүрсжүүлэн аваад байна.

Номын соёлт ертөнц ТББ-тай хамтран “Оюунлаг Алтайчууд” номын баярыг зохион байгуулж, зохиолчид хүрэлцэн ирж зохиол бүтээлээрээ үзэсгэлэн гаргасан ба энэ үеэр 9 төрлийн арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор 350 иргэн хамрагдаж, мэдээлэл авлаа.

Эрүүл мэндийн салбарт: Коронавируст халдвар батлагдсан 132 тохиолдлыг Нэгдсэн эмнэлэг, Эрүүл-Ирээдүй эмнэлгүүдэд хуваарилан хэвтүүлж, эмчлүүллээ.

Дархлаажуулалтад хамрагдвал зохих 43485 хүнээс 1-р тунд 43252 хүн буюу 99.4 хувь, 2-р тунд 39138 буюу 90 хувь 3-р тунд 6476 буюу 14,8 хувь нь хамрагдаад байна.

10 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар коронавируст халдвар 11301 батлагдсанаас 0-17 насны хүүхдийн өвчлөл 2675 буюу 23,6 хувийг эзэлж байна. Боловсролын байгууллагад нийт 13563 суралцагч суралцаж байгаагаас 2139 буюу 15.7% нь коронавируст халдвараар өвчилсөн байна.

Гамшгийн сангаас 16800.0 мянган төгрөгийн санхүүжилт авч оношлуурын нөөцөө бүрдүүллээ.

Хүний нөөцийн чиглэлээр: Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан Коронавируст (КОВИД-19)-ын халдварын үеийн оношлогоо эмчилгээ сэдэвт сургалтад 4 албан хаагч, НҮБ-ын Хүүхдийн сан, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвөөс зохион байгуулсан дэмжлэгт хяналт хийх тандагч бэлтгэх цахим цуврал сургалтад 2, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвөөс зохион байгуулсан “Дисбактериоз” болон “Covid-19 халдвартай хүүхдийн амьсгалын дутагдлын оношилгоо, эмчилгээ” сэдэвт онлайн сургалтад 30, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Тандалт судалгааны албанаас зохион байгуулсан “Хүүхдийн нүдний эрүүл мэндийн өнөөгийн байдал” сэдэвт цахим сургалтад 37, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас 2020 онд Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан,зөвлөмжийг танилцуулах цахим хэлэлцүүлэгт 3, ЭМХТ-с зохион байгуулсан “Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах” болон “Эх нярайн тусламж үйлчилгээний аюулгүй байдал”, “Шинэ коронавируст халдварын эмнэлгийн тусламж

үйлчилгээнд үзүүлж буй нөлөөлөл” сэдэвт цахим сургалтад 54, Улсын онцгой комисс, ЭМХТ хамтран зохион байгуулсан Коронавирүст халдварын үеийн тандалт, хариу арга хэмжээ, оношилгоо эмчилгээний түр зааврыг хэрэгжүүлэх тухай” цахим сургалтад 150, халдварын батлагдсан тохиолдлын хавьтлын болон кластерийн судалгаа, мэдээлэлд дүн шинжилгээ хийх сургалтад 26, "Монгол Улсын Засгийн газраас эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулахаар хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээ" сэдэвт нөхөн үржихүйн үндэсний IV цахим зөвлөгөөнд 5, ЭМЯ-аас Эрүүл мэндийн салбарын санхүүгийн менежментийн чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулахтай холбоотой зааварчилааг хүргэх цахим сургалтад 2, нийт 11 удаагийн сургалт, зөвлөгөөн, хэлэцүүлэгт давхардсан тоогоор 313 албан хаагч хамрагдаж, чадавхжлаа.

Эмнэлгийн тусламж үйлчилгээний талаар: Аймгийн хүн амын төрөлт, өвчлөл, нас баралтын 2020 оны жилийн эцэс, 2021 оны 9 дүгээр сарын үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулсан дүгнэлт мэдээллийг байгууллагын болон и-оффис цахим хуудаст нээлттэй байршууллаа. 2021 оны эхний 9 сарын байдлаар 978 эхээс 983 хүүхэд амьд төрж, амьгүй төрөлт 7, нас баралт 236, хэвтэн эмчлүүлсэн 12303, ор хоног 100933, бүгд үзлэг 207272, жирэмсний хяналтад шинээр 751, шинэ хорт хавдрын өвчлөл 26, осол гэмтлийн өвчлөл 851, түргэн тусламжийн дуудлага 8544 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

Бусад ажлын чиглэлээр: “Цусаа бэлэглэж, цохилох зүрх бүхнийг аваръя” болзолт уралдааны удирдамжийг боловсруулан харьяа байгууллагуудад хүргүүллээ.

Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны мөнгөн тэтгэмжийг 54 албан хаагчид олгон 221.0 сая төгрөгийг зарцууллаа. Оны эхнээс өссөн дүнгээр 757.0 сая төгрөгийг 170 албан хаагчид олгосон байна.

Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг иргэдэд сурталчилан таниулах “Нээлттэй хаалганы өдөр” -т Нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаахын нэгдсэн эмнэлэг хамтран оролцож ард иргэдэд коронавирусийн халдварт өвчний мэдээлэл, сурталчилгаа хийх, иргэдийн биеийн жингийн индекс хэмжих, артерийн даралт үзэж эрүүл мэндийн зөвлөгөө өглөө.

Сурталчилгаа, мэдээлэл: Олон нийтэд чиглэсэн цаг үеийн мэдээ мэдээллийг TV шторик 2 удаа, МонЦаМэ агентлагаар 4, Алтай радиогоор 4 удаагийн мэдээлэл хийлээ.

Байгууллагын www.emg.gov.mn веб хуудаст 50 мэдээлэл, <https://www.facebook.com/gaaemg> цахим хуудаст 105 мэдээлэл байршуулж 28849 хүний хандалт авч, 4099 хүн цааш нь түгээсэн байна.

НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран хэрэгжүүлж буй “Бага насны хүүхдийн цогц хөгжил” хөтөлбөрийн хүрээнд Есөнбулаг сумын 0-5 насны хүүхэдтэй 200 эцэг эхэд “Бага насны хүүхдийн эрүүл мэнд”-ийн чиглэлээр цахим сургалт зохион байгуулж, чадавхжууллаа.

Гэр бүлийн чиглэлээр: НҮБ-ын Хүүхдийн сангийн ажлын хэсэг орон нутагт ажиллаж байгаатай холбогдуулан “Кейс менежмент”, “Хүүхдийн эсрэг хүчирхийллээс

урьдчилан сэргийлэх INSPIRE стратегийн тойм сургалт”, Гэрээр айлчлах хөтөлбөрийн хүрээнд “Бага насны хүүхдийн цогц хөгжил ба Хүүхэд хамгаалал” сэдэвт 3 удаагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 80 иргэн хамрагдаж, мэдээлэл авлаа.

Төв суурин газарт шилжин суурьшигчид болон отор нүүдлээр яваа малчин өрхүүдэд нийгэм, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагын үйлчилгээнд холбон зуучлах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хамтран ажиллах зорилгоор “Шилжин суурьшигчдад тусалъя” төслийг хэрэгжүүллээ.

Хүүхдийн төлөө зөвлөл болон Хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжиж, хуулиар хүлээсэн чиг үүргийн биелэлтийг хангуулах, шинээр томилогдсон гишүүдийг чадавхжуулах, арга зүй удирдлагаар хангах, хүчирхийлэл, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа нөлөөллийн арга хэмжээг эрчимжүүлэх, эрсдэлт нөхцөл дэх гэр бүл, хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлэх зорилгоор “Хүчирхийлэлгүй ирээдүйн төлөө хамтдаа” арга хэмжээг зохион байгуулж, уг арга хэмжээний хүрээнд 3 удаагийн сургалт зохион байгуулж, нийт 204 албан хаагч, эцэг эх оролцож чадавхжлаа.

Баривчлах шийтгэл хүлээсэн иргэдэд зөв дадал хэвшлийг бий болгох зорилгоор зан үйлд нь нөлөөлөх албадан сургалтыг аймгийн Цагдаагийн газартай хамтран зохион байгуулж, 6 хүнийг хамрууллаа.

Нэг цэгийн үйлчилгээний төвийн мэргэжилтнүүдийг ажлын байранд нь дагалдуулах сургалтад 2 албан хаагч, оюутан залууст сэтгэл зүй, гэр бүл, эрүүл мэндийн боловсрол олгох, хорт зуршлаас татгалзах, залуучуудын сайн дурын ажлын оролцоо хувь нэмрийг нэмэгдүүлэх, эерэг хандлага төлөвшүүлэх сургалтад 130 оюутан, нийт 2 удаагийн сургалтад 132 албан хаагч, оюутан хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүлж, мэдээлэл авлаа.

Хүүхдийн хөгжил хамгааллын чиглэлээр: Ерөнхий боловсролын сум дундын дотуур байр, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчдын дотуур байранд амьдарч байгаа хүүхдүүдийн хүүхэд хамгаалалтай холбоотой хууль эрх зүйн мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөв хүн болон төлөвшихөд нь туслах зорилгоор дотуур байранд амьдарч байгаа 148 хүүхдэд “Хүүхэд хамгаалал- хууль бидний амьдралд” сургалтыг зохион байгуулж, мэдээлэл хүргэлээ.

“Оролцоод хөгжье” хүүхдийн үндэсний цахим чуулганыг орон нутагт зохион байгуулж, 31 иргэн оролцож, мэдээлэл солилцлоо.



К
орон
овир
усий
Н

халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор 5 дахь удаагийн дархлаа дэмжих багц олгох ажлыг зорилтот өрхийн 108 хүүхдийг хамруулан зохион байгууллаа.

Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газартай хамтран усан спортоор хичээллэх сонирхолтой 30 гаруй хүүхдэд төлбөрийн хөнгөлөлт үзүүлэн, хичээллэх нөхцөлийг бүрдүүллээ.

Хүүхдэд тулгамдаж буй аливаа асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Хүүхдээ сонсох өдөр”-ийг 10 дугаар сарын 19-ны өдөр зохион байгуулан, 55 сурагч оролцож үзэл бодлоо илэрхийллээ.

Дэлхийн “Охидын эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан “Ээж охидын өдөрлөг” арга хэмжээг зохион байгуулж, 40 ээж, 48 охин оролцож, ээж, охидын харилцаа, тулгамдаж буй асуудал, цахим орчны аюулгүй байдал, зохистой хэрэглээ, охидын бэлгийн боловсрол зэрэг сэдвүүдээр мэргэжлийн сэтгэл зүйч, эмч, холбогдох байгууллагаас урьдчилан сэргийлэх зөвлөгөө, мэдээлэл хүргэлээ.

Хүүхэд багачуудыг эрсдэлээс хамгаалах, эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр “Эрхээ хамгаалахад бидний оролцоо” сургалтыг зохион байгуулж, 25 хүнийг хамруулан, мэдээлэл хүргэлээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын хурлаар 7 хүүхдийг оруулж, 4 хүүхдийн байнгын асаргааг сунгаж, 3 хүүхдийг шинээр байнгын асаргаанд оруулж шийдвэрлэсэн.

Залуучуудын чиглэлээр: Залуучуудын байгууллага үүсч хөгжсөний 100 жилийн ой, Залуучуудын хөгжлийн сарын аяны хүрээнд аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хөдөлмөр халамжийн, үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Мэргэжлийн сургалт үйлдвэрийн төв хамтран “Аз жаргалтай гэр бүл” хандивын аяныг зохион байгуулж, 1 гэр бүлд шалтай, давхар бүрээстэй гэр бэлэглэн, залуу хосын гэрлэх ёслолын хүндэтгэлийн арга хэмжээг Гэрлэх ёслолын өргөөнд зохион байгууллаа.





Уур амьсгалын өөрчлөлт, цэвэр агаарын төлөөх хүүхэд залуусын сүлжээнд оролцож буй байгууллагуудын төлөөлөлтэй уулзаж нэг жилийн хугацаанд хийсэн ажлыг дүгнэх, уур амьсгалын өөрчлөлтийн мэдээлэл олгох, зураглал хийх аргачлал сайжруулах, блог хөтлөх болон нөлөөлөл хийх арга зүйд сургах зорилгоор сайн дурын хүүхэд залуучууд,



сургагч багш нарт сургалт зохион байгуулж, чадавхжууллаа.



Цэвэр агаар төслийн багийнхан аймгийн удирдлагууд болон ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй нэгдсэн уулзалт зохион байгуулж, тус аймагт хэрэгжиж буй төслүүдтэй танилцан, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өглөө. Уулзалтын үеэр Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх болон “Орон нутгийн ногоон хөгжлийн бодлого”-д хүүхэд залуусыг дэмжиж, хамтран ажиллах “Амлалт” баримт бичигт гарын үсэг зурж баталгаажууллаа. Гэр бүлийн хүчирхийлэл, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, согтуугаар үйлдэгдэж буй гэмт хэрэг, хорт зуршлын эсрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Ойлголцоход нэг л хором”, “Хорт зуршлын эсрэг хамтдаа” хэсэгчилсэн арга хэмжээг тус тус зохион байгуулж байна. Арга хэмжээний хүрээнд хамтарсан хяналт, шалгалтыг зохион байгуулж, иргэдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл өгч, архи, тамхи борлуулдаг 50 дэлгүүрт зөвлөмж, сэрэмжлүүлэг

хүргэн, худалдаа үйлчилгээний мэдээллийн самбарт байршуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Цар тахлын үед мэдээ мэдээлэл, үйлчилгээг цахимаар дамжуулан хүргэх, залуучуудын хөгжлийн төвүүдийн үйлчилгээг олон нийтэд сурталчилах, залуучуудын хөгжил оролцоог дэмжих, олон улсын сайн туршлага, залуучуудад ээлтэй үйлчилгээг бий болгох зорилгоор “Залуус цахим телевиз” пэйж хуудаст нэгдэн, сард нэг удаа ажлын тайлангаа видео хэлбэрээр танилцуулж хэвшлээ.

Хөдөлмөр, халамжийн чиглэлээр: Нийт 11 ажлын байрны захиалга ирснийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдэд сурталчиллаа. Ажлаас чөлөөлөгдөн ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлтэй 10 иргэнийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэн тодорхойлолт гарган өглөө.

Орон нутгийн залуучуудын бизнес санааг дэмжих, залуучуудаар удирдуулсан брендийг бий болгох зорилгоор “Startup weekend Говь-Алтай” хөтөлбөрийг аймгийн Засаг даргын Тамгын газар, Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газар, “Стартап Монгол” ТББ хамтран зохион байгуулж, 21 баг оролцож бизнес санаа, загвараа танилцуулсанаас 1-р байрт шалгарсан багт Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 10.0 сая төгрөгийн буцалтгүй дэмжлэг, 2, 3 дугаар байрт шалгарсан багуудад тус бүр 10.0 сая төгрөгийн зээл олгохоор шийдвэрлэж, үйл ажиллагааг нь дэмжлээ.

Даатгалын чиглэлээр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар зохион байгуулагдаж байгаа “Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолтод хяналт шалгалт хийх аян”-ы хүрээнд аймгийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дахин магадлах дэд комисс ажиллаж, 1710 иргэний картыг шалгаж, 92.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Нийгмийн даатгалын сангаас үйлчилгээ авагч иргэдийн тэтгэврийг 09 дүгээр сарын 01-нд багтаан олгож, олгогдоогүй тэтгэвэр тэтгэмжийн өглөггүй ажиллалаа. Аймгийн хэмжээнд өндөр насны тэтгэвэр авагч 8580 хүнд 3195.6 сая төгрөгийг олголоо. Шинээр тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан өндөр настан 50, тахир дутуу 18, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 2, нийт 70 даатгуулагчийн тэтгэврийн баримт материалыг хүлээн авч хуулийн хүрээнд шийдвэрлэлээ.

Тэтгэмжийн даатгалын сангаас жирэмсэн амаржсаны тэтгэмж 81 хүнд 134.5 сая, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 180 хүнд 22.3 сая, оршуулгын тэтгэмж 20 хүнд 20.0 сая, ажилгүйдлын тэтгэмж 18 хүнд 10.6 сая төгрөгийг тус тус олголоо. Сайн дурын даатгалд 74 хүн хамрагдсанаас ажилгүй 59 хүн, 0-3 насны хүүхдээ асарч буй 15 эх байна.

Эрүүл мэндийн даатгалд 572 иргэнийг хамруулж 41.7 сая төгрөг ЭМД-ын санд хуримтлагдлаа.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлаар 294 хүн орж, 42 хүн шинээр хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгож, 207 хүний групп сунгагдлаа. Цуцлагдсан 43 хүн байна.

ДОЛОО. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний санхүүжилтээр аймгийн хэмжээнд усны тооллого, судалгааны ажлыг Хүйсийн говь-Цэцэг нуур, Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргаатай хамтран хийж гүйцэтгэлээ.

Орон нутгийн тусгай хамгаалалттай 6 газарт иргэд, олон нийтэд зориулан угтах хаалга, мэдээллийн самбар, тэмдэг тэмдэглэгээ байршуулах ажлыг НҮБ-ийн "Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь" төслийн санхүүжилтээр хийж гүйцэтгэлээ. Нийт газар нутгийн 55.84 хувь /улсын тусгай хамгаалалттай газар нутаг 33,8 хувь, орон нутгийн тусгай хамгаалалттай газар 22,04 хувь/ тусгай хамгаалалттай газрын сүлжээнд хамрагдаад байна.

"АйТиЭм" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд "Ховор амьтдын өлгий Алтай нутгаар аялцаа" уриатай оролцож, 2500 иргэнд аймгийн аялал жуулчлалын талаар мэдээ мэдээллийг хүргэлээ. Мөн нутгийн брэнд бүтээгдэхүүн болох газрын алим, ингэний хоормог, суль, сулхирын гурил, арвайн гурил, Баян-Алтай сүүтэй цайг үйлдвэрлэгч, борлуулагч иргэд, аж ахуй нэгжүүдийн төлөөллийг дэмжин оролцуулж, бүтээгдэхүүнээ сурталчилан, борлууллаа.

Уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шалгалт хийн зөвлөн туслах, нөхөн сэргээлт хийсэн талбайг хүлээн авах ажлаар Есөнбулаг, Чандмань, Цогт, Цээл, Бугат, Тонхил, Шарга сумдад ажиллаж мэргэжил аргагүйн зөвлөгөө, үүрэг чиглэлийг өглөө.

Тайлант хунацаанд Есөнбулаг сумын нутагт эвдэгдэн орхигдсон 6.14 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэлээ.

"Алтайн Хүдэр" ХХК- тээвэрлэлтийн замд ашиглагдсан 5 карьерын 16 га талбай, "Цогт эрин транс" ХХК уурхайн олборлолт явуулсан 22,57 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн нь стандартын шаардлага хангаагүй тул засаж сайжруулах чиглэл өгч ажиллалаа.

Хог ангилах, нягтаршуулах цех, ландфилийн хогийн цэг байгуулах ажлын хүрээнд хатуу хог хаягдлын менежментийн бодлого боловсруулах, сургагч мэргэжилтэн тус аймагт ажиллаж, аймгийн хог хаягдлын менежментийн стратеги төлөвлөгөөний боломжит хувилбаруудыг танилцуулах, баримт бичиг боловсруулах ажилд санал авах, хэлэлцүүлэх, энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмын төслийг хэлэлцүүлэх, шинэ ландфилийн газар, ажлын явцтай танилцах, нягтруулан тээвэрлэх төв, пүү, дахин боловсруулах цэгийн газар, ажлын явцтай танилцах зэрэг ажлыг зохион байгууллаа.

Ус цаг уур орчны шинжилгээний чиглэлээр: Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний ажлын хөтөлбөрийн дагуу Говь-Алтай аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд цаг уурын 6 өртөөнд 3 цаг тутамд, цаг уурын 14 харуулд 8 цаг тутамд дэлхийн цаг уурын байгууллагын хөтөлбөрийн дагуу агаарын даралт, агаар, хөрсний гадаргын температур, агаарын чийгшил, хур тунадас, салхи, цасан бүрхүүлийн тархац ба зузаан (цас тогтсон үед), агаарын үзэгдэлд байнгын ажиглалт хийж байна.

Мөн гадаргын ус судлалын 4, нуур судлалын 1 харуулд усны түвшин, урсгалын хурд, цас, мөсний үзэгдэл, үерийн түвшний ажиглалт хэмжилтийг хийсэн.

Алтай хотын агаарт агуулагдаж байгаа хүхэрлэг хий /SO₂/ болон азотын давхар исэл /NO₂/-ийн хэмжээг 08, 14, 20 цагуудад тогтмол хэмжиж хэмжлийн үр дүнг 10 хоног тутамд tsag-agaar.mn цахим хуудсанд байршуулж байна.

НҮБ-ийн Хүүхдийн сангийн санхүүжилтээр Алтай хотын агаарын чанарыг тодорхойлох зорилгоор агаар дахь тоосонцор хэмжих бага оврын Purple air PA-II-SD 5ш багажийг агаарын бохирдол ихтэй бүсүүдэд суурилуулан хэмжилт хийж байгаа бөгөөд Алтай хотын агаарын чанарын үзүүлэлтийг 5 цэгт нэгэн зэрэг хэмжих боломж бүрдэж байна. Мөн хэрэглэгч хүссэн үедээ агаарын чанарын мэдээллийг авах бүрэн боломжтой.

НАЙМ.ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Байгаль орчин, геологи уул уурхай, газар геодези зураг зүйн хяналтаар: Төлөвлөгөөт хяналт шалгалт 12, төлөвлөгөөт бус шалгалт 1, зөвлөн туслах үйлчилгээ

3, нийт 16 шалгалт, зөвлөн туслах үйлчилгээг зохион байгуулж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 13 албан шаардлага, 3 зөвлөмж хүргүүлж, 1.8 сая төгрөгийн торгууль ногдуулан, хэрэгжилийг хангуулан ажиллаж байна.

Дэд бүтцийн хяналтаар: Нийт 8 объектод төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийн арилгуулахаар 7 албан шаардлага, 7 объектод зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, 36 заалт бүхий 6 зөвлөмж, 32 объектод урьдчилан сэргийлэх хяналтыг хийж 81 зөрчил илрүүлэн, албан шаардлага хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.

Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын даргын баталсан 2021 оны 01/73, 01/74 дугаар удирдамжийн хүрээнд холбогдох хяналт шалгалтыг тус тус хийж, 134 заалт бүхий 19 хугацаатай албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Нийгмийн хамгааллын хяналтаар: 2021 онд үйл ажиллагаа эхлүүлсэн болон сэргээсэн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулж, 3 аж ахуйн нэгж байгууллагад албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

МХЕГ-ын даргын 2021 оны 08 дугаар сарын 11-ны өдрийн баталсан 01/129 дугаар удирдамжийн хүрээнд ажилгүйдлийн даатгалын сан болон сангаас дэмжлэг үзүүлсэн ААН байгууллагуудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийн шалгалтын дүнг даргын дэргэдэх зөвлөлийн хэлэлцүүлэн, МХЕГ-т хүргүүлэн цахим системд бүртгэлээ.

Аймгийн хэмжээнд 1896 даатгуулагч иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа тогтоосон байдалд хяналт шалгалт хийх аяныг зохион байгуулан 1554 буюу 97.7%-ийн гүйцэтгэлтэй байна. Шалгалтын явцад ижил мэргэжлийн эмчийн үзлэгт 129 иргэнийг хамруулж, 3 иргэнийг цахимаар, 6 иргэнийг биеэр дуудаж магадлалаа. ХЧА-ын хугацааг дуусгаад цуцлах саналтай 4 иргэн, нас

барсан 10 иргэний ХЧА-ыг зогсоож, оношийн баталгаажилт хангалтгүй 60 иргэний ХЧА-ыг орон нутгийн ЭХМК-оор дахин магадлуулж, 29 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг цуцалж, өндөр насны тэтгэвэрт 7 иргэнийг шилжүүлж, ЭХМК-оор дахин магадлуулах буюу ижил мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулах саналтай 36 иргэн байна.

Төлөвлөгөөт бус хяналт шалгалт: Алтайн Хүдэр ХХК-д төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж, 5 заалттай улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлэн, нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлүүлэхээр 2954.6 мянган төгрөгийн акт тогтоов.

Хөдөлмөрийн хяналтаар: 2 төлөвлөгөөт шалгалтаар 3.5 сая төгрөгийн торгууль, 100.9 сая төгрөгийн нөхөн төлбөрийн акт, 2 зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж 2 зөвлөмж, шинээр үйл ажиллагаа явуулж байгаа 3 аж ахуйн нэгжид 3 албан шаардлага, замын үйл ажиллагаа явуулж байгаа 2 аж ахуйн нэгжид 2 албан шаардлага тус тус хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Эрсдэлийн үнэлгээ хийсэн байдалд тандалт судалгаа хийж танилцуулгыг МХЕГ-т хугацаанд нь хүргүүллээ.

Эм, биобэлдмэлийн хяналтаар: МХГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу Цогт сумын Эрүүл мэндийн төв, Баян-тоорой тосгоны Эрүүл мэндийн төв, Цогт сумын “Есөн төгөлдөр” эмийн сан, “Есөн тойромт хайрхан” эмийн санд тус тус төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, 32 заалт бүхий хугацаатай 4 албан шаардлага хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Боловсрол,соёлын хяналтаар: МХЕГ-ийн даргын 08 дугар сарын 11-ний өдөр баталсан 01/130 дугаар удирдамжийн дагуу 16 цэцэрлэг, 15 сургуулийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт, 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Боловсрол, соёлын хяналтаар 13 төлөвлөгөөт шалгалт, 3 зөвлөн туслах үйлчилгээг үзүүллээ.

Хүнсний чанар, стандартын хяналт: МХГ-ын даргын баталсан 08/118, 08/127, дугаар удирдамжийн дагуу Цогт сумын Баянтоорой тосгоны Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, хүнсний худалдаа эрхлэдэг 3 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалтыг тус тус хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 5 албан шаардлага хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.

МХГ-ын даргын баталсан 08/108 удирдамжийн дагуу Баянтоорой тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээнд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, зөвлөмж хүргүүлэв.

МХЕГ-аас ирүүлсэн 01/05, 01/48 удирдамжийн дагуу Есөнбулаг сумд үйл ажиллагаа явуулж буй хоол үйлдвэрлэлийн 1 аж ахуйн нэгж, 2 хүнсний худалдаа эрхлэгч, 2 гурилан бүтээгдэхүүний үйлдвэр, 1 бейкерийг хамруулан урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.

Нэгдсэн лаборатори:Лабораторид 10 байгууллага, 4 аж ахуй нэгж, 4 иргэнээс ирүүлсэн хүнсний бүтээгдэхүүний 28 сорьцод 178 үзүүлэлт, ундны усны 20 сорьцод 227 үзүүлэлт, орчны 2 сорьцод 12 үзүүлэлт, таримал ургамлын 6 сорьцод 10

үзүүлэлтээр хими, нян, хорио цээрийн шинжилгээ хийхэд ундны усны 17 сорьц 31 үзүүлэлт, хүнсний 3 сорьц 3 үзүүлэлт, орчны 2 сорьц 2 үзүүлэлтээр стандартын шаардлага хангаагүй үзүүлэлттэй байна. Шинжилгээний төлбөр 3983.0 мянган төгрөгийг холбогдох дансанд 100 хувь төвлөрүүллээ.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР